

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар A/11

Арвайхээр сум

**Магадлан хэлэлцэх зөвлөлийн
бүрэлдэхүүн томилох тухай**

Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн “Журам батлах тухай” А/419 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Эхийн ноцтой хүндрэл, эхийн болон перинатал эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэгдүгээр, “Тав хүртэлх насны хүүхдийн эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд эндсэн эндэгдлийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тохиолдол бүрийг журамд заасан хугацаанд хэлэлцэн, хурлаас гаргасан зөвлөмжийн хэрэгжилтийг хянах, эндэгдэлд нөлөөлсөн шалтгаан, хүчин зүйлсийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг (Зөвлөлийн гишүүн)-дэд үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга (Ю.Ичинноров)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Зөвлөлийн бүрэлдэхүүн томилох тухай” А/02 дугаар тушаал, 2023 оны 3 дугаар сарын 14-ны өдрийн “Эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртлэх насны хүүхдийн эндэгдэл, амьгүй төрөлтийг магадлан хэлэлцэх зөвлөлийн бүрэлдэхүүн томилох” тухай А/07 тушаалыг тус тус хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Н.ОЮУНТУЯА

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
 04 дугаар сарын 29-ны өдрийн 411 дугаар
 тушаалын нэгдүгээр хавсралт




ЭХИЙН НОЦТОЙ ХҮНДРЭЛ, ЭХИЙН БОЛОН ПЕРИНАТАЛ
 ЭНДЭГДЛИЙГ МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН
 БҮРЭЛДЭХҮҮН

- Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн Эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн Хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн яамны Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн
- Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн 2 гишүүн
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал
 Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг судлаач эмч
 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Эх барих, эмэгтэйчүүдийн зөвлөх эмч
- Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн зөвлөх эмч

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
 04 дүгээр сарын 22-ны өдрийн 411 дугаар
 тушаалын хоёрдугаар хавсралт



ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭМНЭЛГИЙН
 БОЛОН ЭМНЭЛГИЙН БУС НӨХЦӨЛД ЭНДСЭН
 ЭНДЭГДЛИЙГ МАГАДЛАН ХЭЛЭЛЦЭХ ЗӨВЛӨЛИЙН
 БҮРЭЛДЭХҮҮН

Зөвлөлийн дарга: Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг
 Эрүүл мэндийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний
 хэлтсийн Хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан
 мэргэжилтэн

Гишүүд: Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын
 хэлтсийн Эрүүл мэндийн салбарын бодлого, зохицуулалт
 хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны Хүүхэд судлалын мэргэжлийн салбар
 зөвлөлийн 2 гишүүн

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний
 хэлтсийн дарга

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний
 хэлтсийн Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарын
 асуудал хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусламж, үйлчилгээний
 хэлтсийн Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан
 мэргэжилтэн

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал

Эмгэг судлалын онош, дүгнэлт гаргасан анатомийн эмгэг
 судлаач эмч

Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Хүүхдийн зөвлөх
 эмч

Жич: Тухайн тохиолдолд хамааралтай эмч, мэргэжилтнүүдийг оролцуулна